



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 6

Улаанбаатар хот

Хуулийн төсөл нэн яаралтай хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлын тов, дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлсүгэй.

2. Энэ захирамжийн 1 дэх заалтад заасан хуулийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо (Г.Тэмүүлэн)-нд даалгасугай.

ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



2024000021



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08.
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.01.11 № зг-1 /10.

танай _____ -ны № _____ -т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



000077000200



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим худас: www.cabinet.gov.mn

2014. 01. 11 № ХГ/89
танай -ны № -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ЭНХБАТ ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 12 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000245002613



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр.
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2024.01.11 № 01/199
танай 2024.01.10 ий № ХЭГ/82 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Таны 2024 оны 01 дүгээр сарын 10-ны
өдрийн ХЭГ/82 тоот албан бичгээр ирүүлсэн
Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн
тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт
заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
зөвшөөрлийг олгож байна.

Хүндэтгэсэн,


Б.ЖАВХЛАН

9761000127



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүргэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 01. 10 № 1/132
таний 2024. 01. 10-ны № ХМ/ 82 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.



Б.ЭНХБАЯР

151300004
Doc.yam a5.2023

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлд:

“4.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан бөгөөд уг хуулиар төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихаар хуульчилсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүх шатны төсвийн захирагчид, төрийн өмчйт болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд ханган ажиллаж, хуулийн хэрэгжилтийн хүрээнд хэмнэгдэж байгаа зардал, орон тоо, цалингийн санг бууруулснаар, мөн хуульд заасан автомашин хэрэглэхийг хязгаарлах, төсвийн байгууллагуудад дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, албан томилолтоор онгоцоор явах бол зөвхөн энгийн ангиллаар зорчих болон төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, цахилгаан, дулаан, эрчим хүчний хэрэглээг хэмнэх зэрэг төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанаас хэмнэх боломжтой зардлуудыг бууруулснаар нийт 5,765.2 сая төгрөгийн зардлыг 2022 оны төсвийн жилд хэмнэсэн бөгөөд 2023 оны төсвийн хуулиар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж нэг их наяд төгрөг хэмнэхээр төлөвлөж, жилийн эцсийн урьдчилсан дүнгээр амжилттай хэрэгжүүлж ажилласан байна.

Түүнчлэн, төсвийн хөрөнгийг шууд хэмнэж болох дээрх заалтуудаас гадна төсвийн ерөнхийлөн захирагчид нь чиг үүрэг давхардуулсан орон тоог нэмэгдүүлэхгүй байх, Засгийн газраас тогтоосон цалин хөлсний нийтлэг жишгээс цалин, урамшууллыг нэмэгдүүлж олгохгүй байх замаар цалин хөлсний зардлыг нэмэгдүүлэхгүй байх, байгууллагуудад шаардлагатай бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээр зохион байгуулах, захирагааны зориулалтаар барилга, хөшөө дурсгал барих санал гаргахгүй байх зэргээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг батлах үед буюу 2022 оны эхний улирлын байдлаар манай улсын эдийн засгийн өсөлт -3.9 хувьтай гарч байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засаг өмнөх оны хагас жилээс 6.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эдийн засгийн бодит өсөлтийг салбараар авч үзвэл Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжих боомтын болон дэд бүтцийн томоохон төслийн үр дүнд бий болсон экспортын сэргэлтийн нөлөөгөөр уул уурхайн салбар 45.2 хувиар тэлж, түүнийг дагасан тээвэр ба агуулахын үйл

ажиллагааны салбар 74.0 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.6 хувиар, үйлчилгээний салбар 7.4 хувиар тус тус өссөн нь нийт өсөлтийг дэмжих гол хүчин зүйл болжээ.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлснээр ашигт малтмал экспортлох үйл ажиллагаа эрчимжиж, нүүрсний экспорт өмнөх онуудын түвшингээс хоёр дахин өсөж, орлого нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл сайжирч, гадаад валютын албан нөөц 4,5 тэрбум амдолларт хурсэн байна.

Экспортын орлого, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд инфляцийн хурд харьцангуй удааширч 2023 оны жилийн эцсийн байдлаар эдийн засаг 6.8 хувиар өсч, дотоодын нийт бүтээгдэхүүн 36.7 их наядаас 63.3 их наяд болж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5.220 ам.долларт хүрч, анх удаа улсын төсөв болон төлбөрийн тэнцэл хамтдаа ашигтай гарсан болно. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж тодорхой үр дүнгээ өгч улсын төсөвт хэмнэлт гарган эдийн засгийн өсөлтэд зэрэгзээр нөлөөлсөн байна. Түүнчлэн Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн дүгнэлтэд “Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсвийг арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдсэнээр төсвийн алдагдал буурах, төрийн өмчит байгууллагуудын ашигт ажиллагаа нэмэгдэх үр дүн гарах боломжийг бий болгосон байна” гэж дурдсан байна.¹

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлэхэд “хэмнэлтийн горим баримталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байхаар, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй” байхаар тус тус заасан хэдий ч төсвийн байгууллага байнга хэмнэлтийн горимд ажиллах нь үйл ажиллагааны үр дүнг бууруулах, улмаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж буурах, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах нөхцөл үүсэхээр байна. Тухайлбал, байгаль, цаг уурын өөрчлөлтийн улмаас өвөлжилт хүндрэх, гамшгийн эрсдэл бий болох зэрэг нөхцөл байдал үүссэн үед орон нутаг дахь төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимоор ажиллах нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх боломж хязгаарлагдах, үйлчилгээгээ хүргэж чадахгүй болох нөхцөл үүсэж байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан орон нутаг дахь төсвийн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг бүрдүүлэх, хуулиар хүлээсэн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

¹ Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасны дагуу хийсэн аудитын тайлан

Хуулийн төсөлд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горим баримталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх зарчмыг хангах хүрээнд хэмнэлтийн зарим хязгаарлалтыг илүү уян хатан болгох чиглэлээр дараахь өөрчлөлтийг тусгана:

1.газар нутгийн хэмжээ, алслагдмал байдал, хүн амын тоо, тархан суурьшил зэргийг харгалзан нийслэлээс алслагдсан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт автомашин ашиглах зохицуулалтыг тусгана;

2.төсвийн байгууллага, албан тушаалтны гар утасны зардлыг санхүүжүүлэхийг хориглосон зохицуулалтыг өөрчилж, албан ажлын онцлогийг харгалзан шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн албан хаагчийн гар утасны зардлыг санхүүжүүлэхээр тусгана;

3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах зохицуулалтыг хуулиас хасах заалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Хууль батлагдсанаар байгаль, цаг уурын өөрчлөлт, өвөлжилт, хаваржилтийн хүндэрсэн нөхцөл байдлын үед орон нутаг дахь төсвийн байгууллагын үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж бүрдэж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх боломж бүрдэнэ. Орон нутаг дахь төсвийн байгууллагууд автомашин ашиглах зохицуулалттай холбогдох зардлыг 2024 оны батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэх тул төсвийн нэмэлт санхүүжилт шаардахгүй.

Төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан хэмнэлтийн горимыг илүү уян хатан болгож, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломж улам нэмэгдэнэ.

Түүнчлэн, төсвийн сахилга бат, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх хэмнэлтийн горим үргэжлэн хэрэгжихийн зэрэгцээ төрийн үйлчилгээний хүртээмж сайжрах ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал:

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль байхгүй болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийн талаар

Улсын Их Хурлаас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулиар төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихаар хуульчилсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүх шатны төсвийн захирагчид, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хангаж ажиллаж, хуулийн хэрэгжилтийн хүрээнд хэмнэгдэж байгаа зардал, орон тоо, цалингийн санг бууруулснаар, мөн хуульд заасан автомашин хэрэглэхийг хязгаарлах, төсвийн байгууллагуудад дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, албан томилолтоор онгоцоор явах бол зөвхөн энгийн ангиллаар зорчих болон төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, цахилгаан, дулаан, эрчим хүчний хэрэглээг хэмнэх зэрэг төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанаас хэмнэх боломжтой зардлуудыг бууруулсан байна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан эдийн засгийн ангиллаар Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах 2,735.2 тэрбум төгрөгийн урсгал зардлаас гүйцэтгэлээр 2,598.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 137.0 тэрбум төгрөг зарцуулагдаагүй байна. Аудитаар зарцуулагдаагүй үлдэгдэл 137.0 тэрбум төгрөгийг ангилахад Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд 60.1 хувь буюу 83.2 тэрбум төгрөг нь хэмнэгдсэн байна гэж дурдаад “Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсвийг арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдсэнээр төсвийн алдагдал буурах, төрийн өмчит байгууллагуудын ашигт ажиллагаа нэмэгдэх үр дүн гарах боломжийг бий болгосон байна” гэж дүгнэсэн байна.¹

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлэхэд “хэмнэлтийн горим баримталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байхаар, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар тус тус заасан хэдий ч орон нутаг дахь төсвийн байгууллагууд нутаг дэвсгэрийн хэмжээ, алслагдсан байдал, газар нутгийн онцлог, хүн амын тархмал суурьшил зэргээс шалтгаалан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд харилцан адилгүй хүндрэл үүсч төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх боломж хязгаарлагдаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж буурах, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах нөхцөл үүсээд байгаа талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудаас удаа дараа санал, хүсэлт ирүүлсэн байна. Түүнчлэн, энэ жилийн байгаль, цаг уурын нөхцөл байдлын улмаас монгол орны нийт нутгийн 90 гаруй хувьд цасан бүрхээл тогтсон, үүнээс 11 аймгийн 41 сум зудын нөхцөл байдалтай байгаа бөгөөд ихэнх аймагт өвөлжилт хундэрсэн байна.

¹ Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасны дагуу хийсэн аудитын тайлан

Иймд уг хуулийг цаашид орон нутгийн төсвийн байгууллага байгууллага, албан тушаалтан нэг мөр ойлгож, хуулийн үндсэн зорилтыг хангаж, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа асуудлыг судлан, тодорхойлсны үндсэн дээр дараах өөрчлөлтийг тусган Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа:

1.Төрийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж чиг үүрэгтэй аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон төрийн аудитын байгууллага хяналт шалгалт хийх чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд эдгээр байгууллагыг автомашин ашиглах байгуулага, үйлчилгээнд буюу хуулийн 6.5 дахь хэсэгт нэмж тусгана.

Ингэснээр төрийн үйлчилгээг анхан шатанд зохион байгуулж, хүргэх чиг зүүлэх үүрэгтэй орон нутгийн болон анхан шатны байгууллагууд газар нутгийн хэмжээ, алслагдмал байдал, хүн амын тоо, тархан суурьшил зэргээс шалтгаалахгүйгээр иргэд, малчдад цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл хүргэх, отор нүүдлийн үед иргэдээ эргэх, цаг агаарын аюултай нөхцөл байдал, өвөржилт хүндэрсэн үед газар дээр нь очиж шалгах, шуурхай тусламж, дэмжлэг үзүүлэх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зэрэг хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлнэ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.2-т төсвийн байгууллага автомашин хэрэглэх хязгаарлалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг Засгийн газар батлахаар заасан. Иймд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын ашиглах автомашины тоо, төрлийг тухайн аймаг, сумын газар нутгийн хэмжээ, хүн амын болон сумдын тоо, хүн амын тархан суурьшил, дэд бүтэц, авто замын нөхцөл байдал, төвөөс алслагдсан байдал зэргийг харгалзан дээрх журмаар тогтоон хэрэгжүүлнэ.

2.Төсвийн байгууллага, албан тушаалтны гар утасны зардлыг санхүүжүүлэхийг хориглосон зохицуулалтыг өөрчилж, албан ажлын онцлогийг харгалзан шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн албан хаагчийн гар утасны зардлыг санхүүжүүлэхээр хуулийн төслийн 2 дугаар зүйлд тусгалаа.

3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйл буюу дүрэмт хувцастай холбоотой зохицуулалтад зарим байгууллагын тусгай хувцастай холбоотой зохицуулалтыг тусгасан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д "Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байгаа тул хуулийн дээр дурдсан 8 дугаар зүйлээс "эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас" гэснийг хасахаар төслийн 3 дугаар зүйлд тусгалаа.

4.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр, шатахуун, дотоод албан томилолтын зардал"-ыг хориглосон нь зайлшгүй ажлын шаардлагаар хийх тухайлбал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр биечлэн хийх бэлтгэл, галт зэвсэг, хэргийн газрын үзлэгийн сургалт, гал түймэртэй тэмцэх зэрэг сургалтуудыг цахимаар зохион байгуулах боломжгүй тул хүндрэл учирч байгааг

харгалзан сургалт, семинар, хурал, зөвлөгөөний үр ашгийг нэмэгдүүлэх, оновчтой болгох зорилгоор зөвхөн цахим хэлбэрээр зохион байгуулах зохицуулалтыг хуулиас хасахаар төслийн 4 дүгээр зүйлд тусгалаа. Түүнчлэн Төрийн албаны тухай хуулиар заасан төрийн албан хаагчийн нэмэгдэл баталгааг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хязгаарлсан хууль хооронд зөрчил үүсгэж байгаа тул уг хязгаарлалтыг хуулиас хасахаар тусгасан.

Хууль батлагдсанаар байгаль, цаг уурын өөрчлөлт, өвөлжилт, хаваржилтийн хүндэрсэн нөхцөл байдлын үед орон нутаг дахь төсвийн байгууллагын үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж бүрдэж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх боломж бүрдэнэ.

Төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан хэмнэлтийн горимыг илүү уян хатан болгож, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломж улам нэмэгдэнэ.

Түүнчлэн, хуулийн төсөл батлагдсанаар төсвийн сахилга бат, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх хэмнэлтийн горим үргэжлэн хэрэгжихийн зэрэгцээ төрийн үйлчилгээний хүртээмж сайжрах ач холбогдолтой.

---00---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийн талаар**

Улсын Их Хурлаас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулиар төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихаар хуульчилсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүх шатны төсвийн захирагчид, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хангаж ажиллаж, хуулийн хэрэгжилтийн хүрээнд хэмнэгдэж байгаа зардал, орон тоо, цалингийн санг бууруулснаар, мөн хуульд заасан автомашин хэрэглэхийг хязгаарлах, төсвийн байгууллагуудад дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, албан томилолтоор онгоцоор явах бол зөвхөн энгийн ангиллаар зорчих болон төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, цахилгаан, дулаан, эрчим хүчний хэрэглээг хэмнэх зэрэг төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанаас хэмнэх боломжтой зардуудыг бууруулсан байна. Өөрөөр хэлбэл, Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж тодорхой үр дүнгээ өгч улсын төсөвт хэмнэлт гарган эдийн засгийн өсөлтөд зэрэгзээр нөлөөлсөн гэж үзэхээр байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг хэрэгжүүлэхэд “хэмнэлтийн горим баримталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байхаар, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй” байхаар тус тус заасан хэдий ч хэмнэлтийн зарим арга хэмжээ, хязгаарлалтын улмаас орон нутаг дахь төсвийн зарим байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах нехцэл үүссэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Улсын Их Хурлын зарим гишүүд, төрийн болон нутгийн захирагааны байгууллагуудаас хуулийн зарим зүйл, заалт болон хэрэгжилтийн байдалтай холбоотой санал, хүсэлтийг удаа дараа Засгийн газарт ирүүлж байна.

Иймд орон нутаг дахь төсвийн байгууллага хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлж, хуулиар хүлээсэн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа:

1. Төрийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж чиг үүрэгтэй аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон төрийн аудитын байгууллага хяналт шалгалт хийх чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд эдгээр байгууллагыг автомашин ашиглах байгуулага, үйлчилгээнд буюу хуулийн 6.5 дахь хэсэгт нэмж тусгана.

2. Төсвийн байгууллага, албан тушаалтны гар утасны зардлыг санхүүжүүлэхийг хориглосон зохицуулалтыг өөрчилж, албан ажлын онцлогийг харгалзан шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн албан

хаагчийн гар утасны зардлыг санхүүжүүлэхээр хуулийн төслийн 2 дугаар зүйлд тусгалаа.

3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйл буюу дүрэмт хувцастай холбоотой зохицуулалтад зарим байгууллагын тусгай хувцастай холбоотой зохицуулалтыг тусгасан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д "Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байгаа тул хуулийн дээр дурдсан 8 дугаар зүйлээс "эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас" гэснийг хасахаар төслийн 3 дугаар зүйлд тусгалаа.

4.Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг үр ашгийг нэмэгдүүлэх, оновчтой болгох зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр, шатахуун, дотоод албан томилолтын зардал"-ыг хориглосон зохицуулалтыг хуулиас хасахаар төслийн 4 дүгээр зүйлд тусгалаа.

Хууль батлагдсанаар байгаль, цаг уурын өөрчлөлт, өвөлжилт, хаваржилтийн хүндэрсэн нөхцөл байдлын үед орон нутаг дахь төсвийн байгууллагын үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж бүрдэж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх боломж бүрдэх бөгөөд төсвийн сахилга бат, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх хэмнэлтийн горим үргэжлэн хэрэгжихийн зэрэгцээ төрийн үйлчилгээний хүртээмж сайжрах ач холбогдолтой.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн явцын тайланг төсвийн ерөнхийлөн захирагч нараас гаргуулан нэгтгэн Засгийн газарт танилцуулсан. Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхий сайдыг орон нутагт ажиллах үеэр Төрийн хэмнэлтийн хуулиар тогтоосон хязгаарлалтын улмаас орон нутаг дахь төсвийн байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч, төрийн хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрч байгаа талаар дурдаж, хуулийн зохицуулалтыг уян хатан болгох хүсэлтийг тавьсан байна. Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг харгалзан үзсэн бөгөөд хуулийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэл, тулгамдаж байгаа асуудлыг талаар бүх аймгийн Засаг дарга нараас санал авч нэгтгэн дүгнэж, хуулийн төслийг боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуульд 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.5.21, 6.5.22 дахь заалт нэмсүгэй:

"6.5.21.нийслэлээс алслагдсан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар;

6.5.22.төрийн аудитын төв, орон нутгийн байгууллага."

2 дугаар зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын "гар утасны зардал" гэсний өмнө "үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн ", эруүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас" гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн ", 15.2.3" гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдаанд
оролцох албан тушаалтны нэрс**

	Албан тушаал, нэр	Утас
1.	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан	262958
2.	Сангийн сайд Б.Жавхлан	-
3.	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж	99099609
4.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа	99081698
5.	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж	99190219
6.	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хуулийн багийн ахлах Ч.Ариунхур	95951414
7.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Г.Дөлгөөн	90448044